



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.БАТЖАРГАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08.
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.05.30 № НЭГ/1571

танай _____ -ны № _____ -т

Г Асуулгын хариу хүргүүлэх тухай

Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон зарим аймгийн Засаг дарга нараас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хавсралт[№] хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ

000255009505



МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2025.05.26 № 01/1650

танай _____ -ны № _____ -т

Асуулгын хариу хүргүүлэх тухай


Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг 2024 оны 06 дугаар сарын 05-нд батлагдаж тус оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн захирагааны албан хаагчдаар дамжуулан хууль сурталчилах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж батлагдсан Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтад орсон өөрчлөлтөөр жилийн 4 улирлын бэлчээрийг малчин өрхийн анхдагч холбоонд гэрээгээр ашиглаулах зохицуулалтын талаар тулхүү танилцуулан ажиллаж байна.

Газрын тухай хуулийн 52.12-д заасны дагуу "Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээр ашиглаулах гэрээ байгуулах журам, гэрээний загвар" боловсруулах үүрэг бүхий Газар зохион байгуулалт, геодизи, зураг зүйн ерөнхий газартай хамтарсан ажлын хэсгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/107 дугаар тушаалаар байгуулагдсан. Уг ажлын хэсэг нь журмын төслийн анхны хувилбарыг боловсруулан малчдаас санал авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Түүнчлэн Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулийн "7.2-д анхдагч холбоог үүсгэн байгуулах хурлыг энэ хуулийн 7.1-д заасан малчин өрхийн төлөөлөл зохион байгуулж, 7.3-д анхдагч холбоог үүсгэн байгуулах шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ" гэж тус тус заасан. Тиймээс улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээгээр 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар "малчин өрхийн анхдагч холбоо" статус бүртгэл хийгдээгүй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарт "Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль"-ийг сурталчилах, малчин өрхийн анхдагч холбоог байгуулаад аргазүйн дэмжлэг үзүүлэн ажиллах чиглэлийг хургуулсан. Мөн хамтран ажилладаг тесөл, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд анхдагч холбоо-байгуулахыг дэмжин ажиллаж байна.



1301031247

ХОГ/1988



ХОВД АЙМАГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗАР

84149 Наран баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас: 7043-3089
Email:khovd.hhaag@gmail.com

2025. 05. 23. № 153
танай 2025. 05. 05 ны № хэг /1258-т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Н.УЧРАЛ ТАНАА

Малчин өрхийн нэгдсэн холбооны эрхзүйн
байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх
асуулгын хариуг хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 3 хуудастай.

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА





84000 06047

गोपनीय ३ गोपनीय अर्थ ००

उत्तम/ अद्वितीय सं ००

मिल्लिति ००

स/ गोपनीय अर्थ ०० / उत्तम/ अद्वितीय स/ गोपनीय ०० / गोपनीय अर्थ ००
हेतु/ गोपनीय स/ गोपनीय/ गोपनीय/ ० गोपनीय स/ गोपनीय

गोपनीय गोपनीय स/ गोपनीय/ गोपनीय अर्थ ००

गोपनीय/ गोपनीय स/ गोपनीय स/ गोपनीय स/ गोपनीय

अ/ ०
१०८४.०५.०८ ०८८८८८
१०८४.०५.०८ ०८८८८८

ईमेल/ ईमेल : khovd.hhaag@gmail.com ,

फोन/ फोन : ९९९६५४३३५५५५ , गोपनीय अर्थ ०० ८४१४९

गोपनीय गोपनीय गोपनीय

गोपनीय गोपनीय + मिल्लिति + मिल्लिति

**МАЛЧИН ӨРХИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ
ЭРХЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЛААРХ АСУУЛГЫН ХАРИУ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ**

2025 оны 05 дугаар сарын 19

Ховд аймаг

Энэхүү хуулиар малчин өрхийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн болон тэдгээртэй холбогдсон харилцааг зохицулах, бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн нөөцийг хууль тогтоомжид заасны дагуу ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд малчдын оролцоог хангах, малчин өрхийн холбооны тогтолцоог өөрөө удирдах ёсны зарчимд нийцүүлэн зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар заасан байна. Гэвч энэхүү хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Асуулгын дагуу дүгнэхэд:

1. Малчин өрхийн анхдагч, сумын аймгийн, нэгдсэн холбооны тогтолцоо бүрдсэн эсэх, уг холбоонд элссэн малчин өрхийн тоо, гишүүнчлэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл:

➤ Тус аймгийн хэмжээнд малчдын хоршоо 738 байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж, хоршоонд нийт 2952 малчин өрх хамрагдаж байна.

2. Дээрх тогтолцооны дагуу тухайн шатны төрийн бодлого үйл ажиллагаанд малчин өрх, малчдын холбооны эрх ашгийг хангаж, төрийн үйлчилгээ, зээл санхүүгийн хүртээмж нэмэгдэж байгаа эсэх талаар:

➤ Малчин өрхийн нэгдсэн холбооны эрхзүйн байдлын тухай хуулийг сурталчилах, малчдыг мэдээллээр хангах шаардлагатай байна.

➤ Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт малчин өрх хамрагдаж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжин, малчдын орлого нэмэгдэж байна.

3. Энэхүү хууль хэрэгжиж эхэлснээр малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнд хамрагдах, боловсрол эзэмших, ур чадвараа дээшлүүлэх, малчдын залгамж халаа бэлтгэх, бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, өвлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, түүний явц, үр дүнгийн талаар:

➤ Аймгийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн статистикийн тоогоор нийт 3,491,1 мал тоологдож, малчин өрх 9084, мал бүхий өрх 3357, малчдын тоо 14482 байна.

➤ Малчдын залгамж халааг бэлтгэх зорилгоор Хөгжил Политехник коллежид малчны анги шинээр нээгдэж, 2024 онд Дарви сумын 22, 2025 онд Чандмань сумын 26 оюутан тус тус суралцаж байна.

4.Хууль хэрэгжиж эхэлснээр малын эрүүл мэнд, үржил, чанар, ашиг шим дээшлүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, түүний чанар сайжруулах, нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр гарч буй үр дүн:

- Байгаль цаг уурт дасан зохицох чадвартай үржил шимтэй мал өсгөн үржүүлэх чиглэлийн бодлого барин ажиллаж байна. Үүнд: Дарви сумын Сутай үүлдрийн хонь, Алтай сумын Алтайн улаан үүлдрийн ямаа , Булган сумын Торгууд үүлдрийн хэсгийн хонь.
- Аймгийн хэмжээнд махны үйлдвэр 2, сүүний үйлдвэр 2, эсгийний үйлдвэр 1 тус тус ажиллаж, түүхий эдийг үйлдвэрт төлөөлөгчөөр дамжуулан нийлүүлж байна.
- Малчид бэлчээрийг хуваарьтай ашиглах, нөхөн сэргээх, малын тоонд биш чанарт анхаарах, сүргийн эргэлтийн тооцоолол гаргаж, эдийн засгийн эргэлтэнд оруулах талаар малчдад сургалт сурталчилгааны ажил хийгдэж байна.

5.Бэлчээрийг гэрээгээр ашиглах, байгалийн нөөцийг зохистой ашиглах хамгаалах, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах, сэлгэх нүүдэллэх, бэлчээрийг нөхөн сэргээх чиглэлээр гарч буй ахиц, үр дүнгийн талаар:

- Ховд аймгийн нийт газар нутаг нь 76133 мян.км²нутаг дэвсгэртэй үүнээс бэлчээрийн газар нь 53120,5 мян.км² хамарагддаг. Аймаг дундын отрын бүс нутаг 105,2 га газрыг эзэлдэг.
- Нийт нутгийн 11 хувьд бэлчээрийн нөөцтэй, 9 хувьд бэлчээр хүрэлцээтэй, 42 хувьд даац 1-3 дахин хэтэрсэн, 9 хувьд даац 3-5 дахин хэтэрсэн, 29 хувьд бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн үзүүлэлттэй байна. Бэлчээрийн даац олон дахин хэтрэх гол шалтгаанд ихэнх нутгаар бэлчээрийн ургамлын ургалт муу, сумдад малын тоо их байгаа нь нөлөөлж байна.

6. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах харилцааг төлөвлөх, шийдвэр гаргах, гэрээ байгуулах, гэрээг бүртгэх, дүгнэх, бэлчээрийг зохистой ашиглах чиглэлээр тус тус хуулиар хүлээсэн үүргээ төрийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж байгаа байдал, тулгамдаж байгаа асуудал, бэлчээрийн ашиглалт, түүний үр дүнгийн талаар:

- Бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах, эзэмшигүүлэх ажил хийгдээгүй байна.

- Аймгийн газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөнд 6 сумын 11 малчдын хоршоонд 30,9 га газрыг эзэмшиүүлэхээр тусгагдсан байна.

7. Хууль хэрэгжиж эхэлснээр нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын зүгээс малчдын холбооны эрх ашгийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнгийн талаар:

- Малчин өрхийн нэгдсэн холбооны эрхзүйн байдлын тухай хуулийн талаарх мэдээлэл дутмаг байна.

ХОВД АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсандаанзанжанцангийн
өргөн чөлөө 3, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442273
Цахим шуудан: info@bayankhongor.gov.mn
Цахим хаяг: www.bayankhongor.gov.mn

2025.05.19 № 2/678

танай _____ -ны № _____ -т

Г Хариу хүргүүлэх тухай 7

Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Их хурлын гишүүн Ж.Батжаргалын асуулгын хариуг хүргүүлж байна.

1. Малчин өрхийн анхдагч, сумын, аймгийн нэгдсэн холбоонд элссэн малчин өрх, гишүүнчлэл манай аймагт одоогоор бүртгэгдээгүй байна. /Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 13/424 тоот албан бичиг хавсаргав/

2. Төрөөс баримталж байгаа малчдад чиглэсэн “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” “Атар-4” “Цагаан алт” зэрэг хөдөлгөөний талаарх мэдээллийг аймаг, сум, багийн бүх түвшинд мэдээллээр хангаж төрийн үйлчилгээг үзүүлж ажиллаж байна. Тус хөдөлгөөнүүдийн хүрээнд малчдад зээл, санхүүгийн хүртээмж нэмэгдэж 20 сумын хэмжээнд “ШИНЭ ХОРШОО” хөдөлгөөний хүрээнд 2,098 зээл хүсэгчийн өргөдөл хүлээн авч, 84.59 хувь буюу 1,704 зээлдэгчийн 49.67 тэрбум төгрөг зээл олгож, 122 зээлдэгчийн 4.21 тэрбум төгрөгийг зээлийн хүсэлт судлагдаж байна. Зээлийн батлан даалтын сантай хамтран 387 хоршооны 1,559 зээлдэгчидэд 44.31 тэрбум төгрөгийн зээлд баталгаа гаргасан нь нийт зээлдэгчийн 89.22 хувийг эзэлж байна. “АТАР-4” хөдөлгөөний хүрээнд олгогдож буй малчны хоршооны зээл олголт 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 20 зээл хүсэгчийн 5.38 тэрбум төгрөгийн өргөдөл хүлээн авч, 6.04 хувь буюу 2 зээлдэгчийн 0.33 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

3. Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа 24 нэгжээр дамжуулан малчин өрхөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Үүнээс: өрхийн эрүүл мэндийн төв 4, сумын эрүүл мэндийн төв 19, тосгоны эрүүл мэндийн төв 1 тасралтгүй тусламж үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Анхан шатны 24 нэгж мобайл технологийн багцыг бүрэн ашиглаж 2024 онд 27325 малчин иргэдэд үзлэг хийсэн. Баянхонгор аймгийн малчдыг эрүүл

62528023

25-6098
Г.Донжон

мэндийн үзлэгт хамруулж, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Малчдын эрүүл мэндийг дэмжих төсөл”-ийг 2022-2023 онд Австралийн Элчин сайдын яамтай хамтран хэрэгжүүлсэн. Уг төслийн хүрээнд нийт малчдын 41.7 хувийг үзлэг оношилгоонд хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамрагдсан 5682 малчнаас 1147 хүн эрүүл мэндийн эрсдэлтэй гэж оношлогдсон ба дараагийн шатлалын лавлагаа, төрөлжсөн эмнэлэгт нэмэлт шинжилгээ хийлгэх шаардлагатай малчин 633, стационарт онош тодруулах, хэвтэн эмчлүүлэх шаардлагатай 511 малчин байсан. Дээрх эрүүл мэндийн эрсдэлт бүлэгт харьялагдаж байгаа 1147 малчин, онош тодруулах шаардлагатай 633 малчныг илрүүлсэн нь үзлэг оношилгооны үр дүн юм. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд цаашид хэвтүүлэн эмчлэх шаардлагатай дээрх 511 малчдыг системтэйгээр хэвтүүлэн эмчилж, эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ажилласан. Үзлэгт хамрагдсан малчдын 58 хувь нь илүүдэл жинтэй, 43 хувь нь зохисгүй хооллолттой, 36 хувь нь хорт зуршлын хэрэглээтэй байгааг асуумжаар гаргаж, нийгмийн эрүүл мэндийн сургалт, зөвлөгөөнд хамруулсан дээрх төслийн үйл ажиллагааг сумдын өрхийн эмнэлгүүд уламжлал болгон хэрэгжүүлж байна. “Хавдрын эсрэг үндэсний аян-2024” -ийг аймгийн төвд 5 өдрийн турш зохион байгуулж үзлэгт 1361 иргэн хамрагдаж хавдрын урьдал 72, хоргүй хавдар 252, хортой хавдар 13, хортой хавдар байж болзошгүй 19, хяналтын үзлэг 214, бусад өвчлөл 492 илэрсэн. Толгой хүзүүний мэс засал 2, ерөнхий мэс засал 1, нийт 3 мэс засал амжилттай хийгдсэн.

Малчин өрхийн гишүүдийг албан болон албан бус сургалтад хамруулах хүрээнд: Аймгийн хэмжээнд төрийн өмчийн 30 сургуульд 19082 суралцагч, төрийн өмчийн 36 цэцэрлэгт 7551 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдлаа. Политехник коллежид 2024-2025 оны хичээлийн жилд 816, Өлзийт мэргэжлийн боловсролын сургуульд 400, Баянхонгор аймаг дахь ХААИС-ын салбар сургуульд 2024-2025 оны хичээлийн жилд 80 оюутан тус тус суралцаж байна. Эдгээрт нийт 7864 малчин өрхийн суралцагч хамрагдан боловсрол эзэмшиж байна. Насан туршийн суралцахуйн төвөөс хэрэгжүүлдэг боловсрол нөхөн олгох сургалт нь малчидруу чиглэсэн хөтөлбөр бөгөөд 2024 оны байдлаар 25 хүн хамрагдсан ба насаар нь ангилбал: 7-10 насын суралцагч 1, 11-17 насын суралцагч 8, 18-34 насын суралцагч 16 суралцагч байна. Малчин өрхөд зориулж, анхан шат буюу үл мэдэгч, дунд шат буюу бага мэдэгч, гүнзгий шат буюу мэддэг, дараах шат буюу сайн мэддэг гэсэн 4 үе шаттай сургалтыг явуулдгаас гадна малчин өрхийн хүүхдүүдэд зориулж, боловсрол нөхөн олгох сургалтыг тус тус явуулдаг. 2024-2025 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд нийт 24 дотуур байранд нийт 1997 малчны хүүхэд амьдарч, хөгжиж байна. Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг бүх насын иргэдэд амьдралын мөчлөг, насын онцлогт нь тохирсон байдлаар үе шаттайгаар зохион байгуулсан. 2024 онд нийт 134 удаагийн сургалтад 12472 хүн, хүйсээр ангилвал 6114 эрэгтэй, 6358 эмэгтэй хамрагдсан байна. Эдгээрээс малчин иргэн 12,5 хувийг эзэлж байна. Малчин өрхөд чиглэсэн гэр бүлийн

сургалтыг “Хамтдаа шийдье” төсөлт арга хэмжээний хүрээнд зохион байгуулж нийт 1500 гаруй малчин иргэдэд хүрч ажилласан байна.

Малчдын ур чадварыг сайжруулахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөн туслах ажил арга хэмжээ зохион байгуулах хүрээнд: Орон нутгийн бодлогын баримт бичгүүдэд хөдөө аж ахуйн салбар, малчдын талаар тусгагдсан бодлого шийдвэрийн хэрэгжилтийн мэдээллээр хангах, малчдын санал хүсэлтийг сонсох, арга туршлагыг солилцох, цаашид малчдын талаар авч хэрэгжүүлэх орон нутгийн бодлогыг тодорхойлох, малчдын урлаг, спортын авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, биеийн тамир спортоор нөхөрлөх, малчдын оролцоо хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Эрдэнэт сүргийн эзэд” арга хэмжээг 20 сумын 1000 гаруй малчдыг хамруулан зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд “Эрдэнэт сүргийн эзэд-1000 чуулган”, Малчдын дунд соёл урлагийн арга хэмжээ, уралдаан, Малчдын дунд спортын 7 төрөлт тэмцээн, Эмчийн үзлэг зэрэг үйл ажиллагаа зохион байгуулагдсан эдгээр үйл ажиллагаанд давхардсан тоогоор 4900 гаруй малчикд хамрагдсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/39 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01 тогтоолыг хэрэгжүүлэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйлчилгээ, арга хэмжээг төсөл хөтөлбөрүүдийн хэлбэрээр хэрэгжүүлж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/39 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01 тогтоолын дагуу Малжуулах арга хэмжээнд 20 сумын 170 өрхийг хамруулж 1 тэр бум 360 сая төгрөгийг зарцуулсан. “Монголын тэмээн соёл улсын зөвлөгөөн баяр наадам”-ыг Улсын хэмжээнд амжилттай зохион байгууллаа. Үйл ажиллагааны нээлт нутаг нутгаас оролцсон 100 гаруй тэмээчдийн парадаар эхэлж, гурван насны хурдан тэмээний уралдаан, шилмэл буур, шилмэл ингэ, сайхан тэмээтэй ганган хос, буйл зорох, бурантаг томох төрлөөр аваргуудыг тодруулж, тэмээний гаралтай бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, соёл урлагийн цогц арга хэмжээг аймгийн ИТХ, ЗДТГ, Монголын тэмээн соёл уралдааны холбоо, Баянхонгор аймгийн “Ламын гэгээний улаан” тэмээн соёлын холбоотой хамтран зохион байгуулсан. Арга хэмжээнд 10 аймгийн тэмээчдийн холбооны дарга, сумдын удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, малчикд нийт 150 төлөөлөгч оролцсон.

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах, холбогдох мэдээллээр хангах хүрээнд: Аймгийн хэмжээнд зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдөрлөгт зөвлөгөө авсан хүн 727, үйлчилгээ авсан хүн 227, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо 3, гарын авлага 320, зохион байгуулсан байршил 19, Малчны ходонд хурч ажилласан тоо 14 байна. Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулж, 7493 сайн дурын даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдсан. Үүнээс 0-3 настай хүүхдээ асарч байгаа эх 1018, малчид 3952, хувиараа хөдөлмөр эрхлэгч 2325, 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг/эх 157, бусад 41 даатгуулагч байна. 2024 онд 13069 хүнд 107578.1 сая төгрөгийн тэтгэврийг, 1943 хүнд 5078.1 сая төгрөгийн тэтгэмжийг хуулийн хугацаанд тус тус олгосон. Ажилгүйдлийн даатгалын санд 966.94 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 1281.84 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, 528 хүнд 1428.5 сая төгрөгийн тэтгэвэр олгосон. Эрүүл мэндийн магадлалын зөвлөл 31 удаа хуралдаж 2065 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгч асуудлыг шийдвэрлэсэн. Үүнээс шинээр тогтоолгосон 361, сунгалт хийгдсэн 1593, цуцлагдсан 111 хүн байна. Аймгийн Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл нь 10 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, 2024 онд 12 удаагийн хурлаар 69 иргэний өргөдөл, гомдлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

1 Аймгийн 20 сумдын 104 багийн хэмжээнд бэлчээр ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, малын тоо толгойго бэлчээрийн даацад тохируулан өсгөх талаар иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн ажиллаж байна. Мөн өвөлжөө, хаваржааны бус нутгийг малын хөлөөс чөлөөлж, заасан нутгуудад отор хийж, бэлчээрийн ургамалд хөнөөл учруулдаг үлийн цагаан оготонотой тэмцэх ажил, арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг сум бүр боловсруулан, Хууль эрх зүйн яамаар батлуулан дагаж мөрдөн ажилладаг.

Малын үүлдээрлэг байдал, ашиг шиминий гарц чанарыг сайжруулах чиглэлээр орон нутгийн төсвийн хөрөнгөөр малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.





БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Гурван бүсийн өргөн чөлөө 308, 10 дугаар баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64090
Утас: 70440517, Факс: 70440517
Цахим шуудан: bayankhongor@burtgel.gov.mn
Цахим хуудас: www.bayankhongor.burtgel.gov.mn

2025.05.13 № 13/424

танай 2025.05.09 -ны № 5/607 -т

Г АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮС ОРОН
НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХБАЯР ТАНАА

Танай 2025 оны 05 дугаар сарын 09-ний
өдрийн 5/607 тоот албан бичигт дурьдагдсан
"Малчин өрхийн анхдагч холбоо" нэртэй хуулийн
этгээд өнөөдрийн байдлаар хуулийн этгээдийн
цахим мэдээллийн санд албан ёсоор бүртгэгдээгүй
байна.



Баянхонгор аймаг дахь Улсын
бүртгэлийн хэлтэс
Захиргаа
Дарга
Цэдэндамба Мөнхжаргал
2025-05-14 11:30:41



МОНГОЛ УЛС
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

З дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-2315 Факс: 7045-4095

Цахим шуудан: info@uvs.gov.mn


Цахим хуудас: www.uvs.gov.mn

2025.05.09 № 1/755
танай 2025.05.05-ны № ХЭГ/1258-т

ГАЗРИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн ХЭГ/1258 дугаартай албан бичгээр ирүүлсэн асуулгийн хэрэгжилтийг заалт тус бүрээр тайлагнан хүргүүлэв.

Хавсралт 2. хуудастай.



25-5738
8525020424
8525020424

Аймгийн Засаг дарга 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 11.7.55 дугаар үалбаачийн хавсралт

Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн тайлан

№	Асуулга	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Малчин өрхийн анхдагч, сумын, аймгийн, нэгдсэн холбооны тогтолцоо бүрдсэн эсэх, уг холбоонд элссэн малчин өрхийн тоо, гишүүнчлэлийн дэлгэрэнгүй мэдээлэл	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд малчин өрхийн анхдагч, сумын, аймгийн, нэгдсэн холбооны тогтолцоо бүрдээгүй. Манай аймагт Швейцарын хөгжлийн агентлаг "Ногоон алт" төсөл 2013 оноос хойш хэрэгжиж "Бэлчээр ашиглагчийн холбоо"-г 19 суманд байгуулж ажиллаж 83 багт 6667 малчин өрхийг хамруулсан бэлчээр ашиглалтын газартай болсон.
2	Дээрх тогтолцооны дагуу тухайн шатны төрийн бодлого үйл ажиллагаанд малчин өрх, малчдын холбооны эрх ашгийг хангаж, төрийн үйлчилгээ, зээл санхүүгийн хүртээмж нэмэгдэж байгаа эсэх талаар	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын хуулийн хүрээнд малчин өрх, малчдын холбооны эрх ашгийг хангаж, төрийн үйлчилгээ, зээл санхүүгийн асуудлаар дэмжлэг аваагүй. Харин "Шинэ хоршоо- Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд 2024 онд 332 хоршооны 1186 малчин өрх 41.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.
3	Энэхүү хууль хэрэгжиж эхэлснээр малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдах, боловсрол эзэмших, ур чадвараа дээшлүүлэх, малчдын залгамж халаа бэлтгэх, бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, өвлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, түүний явц, үр дүнгийн талаар	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг сурталчилан ажиллаж байна.
4	Хууль хэрэгжиж эхэлснээр малын эрүүл мэнд, уржил, ашиг шимиийг дээшлүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, түүний чанарыг сайжруулах, нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр гарч буй үр дүн	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг сурталчилан ажиллаж байна.
5	Бэлчээрийг гэрээгээр ашиглах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах, сэлгэх нүүдэллэх, бэлчээрийг нөхөн сэргээх чиглэлээр гарч буй ахиц үр дүнгийн талаар	Сумууд жил бүр сумынхаа бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаараа батлуулж ажилладаг бөгөөд бэлчээрийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлснээр бэлчээрээ ашиглах уламжлалыг сэргээх, зохистой ашиглах эрх зүйн орчин үүснэ. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд ашиглалтгүй бэлчээрийг ашиглах, хадлан малын тэжээлийн ургамал тариалах, хөв цөөрөм, мал угаалгын ванн барих, Улийн цагаан огтоно устгалт, малын хашаа, худаг засвар хийгдэж байна.
6	Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах харилцааг төлөвлөх, шийдвэр гаргах, гэрээ байгуулах, гэрээг бүртгэх, дүгнэх, бэлчээийг зохистой ашиглах чиглэлээр тус хуулиар хүлээсэн үүргээ төрийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж байгаа байдал,	Сумууд жил бүр сумынхаа бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллаж байна. Бэлчээрийн менежмент боловсронгуй болгох, бэлчээрийг жилийн 4-н улиралд малын төрөлд тохируулан зүй зохистой ашиглах ажлыг малчдад хэвшил болгох талаар малчдад ухуулга сурчилгаа зохион байгуулахаас гадна жил бүр "Бэлчээр хамгаалах өдөр"-ийн хүрээнд Бэлчээрийг ашиглах, хамгаалах үйл

	тулгамдаж байгаа асуудал, бэлчээрийн ашиглалт, түүний үр дүнгийн талаар	ажиллагааг зохион байгуулах, хариуцлагын тогтолцоог төлөвшүүлэх, малын тоог бэлчээрийн даацаад нийцүүлэн хуваарь сэлгээтэйгээр зохистой ашиглаж сурхад чиглэсэн сургалт мэдээллийг тогмол өгч ажиллаж байна. Хийгдсэн мэдээллүүд: <ul style="list-style-type: none"> • Мал аж ахуйн үйлдвэрлэлд авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа • Бэлчээрийн даацаад тохирсон мал аж ахуй эрхлэх талаар малчдад мэдээлэл • Бууцны хөлд ногоон тэжээл тариалах зааварчилгаа • Нэг ба олон наст ургамал тариалах агратехнологи • Хөдөөгийн усан хамгамжийг сайжруулах зарим арга зам • Орон нутгийн түүхий эдээр гар тэжээл бэлтгэх • Бэлчээрийг сайжруулах арга замууд
7	Хууль хэрэгжиж эхэлснээр нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын зүгээс малчдын холбооны эрх ашгийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах, малын тоо толгой бэлчээрийн даацаад тохируулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил түүний үр дүнгийн талаар	Жил бүр бэлчээрийг мэрэгч амьтан, шавжны хөнөөлөөс бэлчээрээ хамгаалах бүх нийтийн арга хэмжээг сум, багийн түвшинд ХХААГ-аас зохион байгуулж 2024 онд хамгийн өндөр нягтилтай Баруунтуруун суманд 2000 га, Хяргас суманд 9000 га, Малчин суманд 20000 га, нийт 31000 га бэлчээрт царцаатай тэмцэх арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсныг сумын удирдлагуудад хүргүүлж, ургамал хамгааллын арга хэмжээ авч хэрэгжүүлэх заавар чиглэл өгч ажиллалаа. Баруунтуруун сумын хэмжээнд нугын бор эрвээхий, царцааны дэгдэлт их байснаас хугацаанд нь арга хэмжээ авч 7200 га талбайд ургамал хамгааллын арга хэмжээг малчид тариаланчдын оролцоотой зохион байгууллаа. Гамшигт тэсвэртэй орон нутаг төсөлтэй хамтран Ховд, Түргэн сумдад бууцны хөлд тэжээлийн ургамал тариалах технологийг тус бүр 40 малчин өрхөд зааж сурган тариалах үрээр хангтан тариалалт хийсэн. Давст сум орон нутгийн дэмжлэгээр 30 малчин өрхийг өвөлжөөний бууцны хөлд тариалах үрээр хангаж тариалалт хийж тодорхой хэмжээний ургац хураан авсан. Улаангом, Зүүнговь, Давст, Түргэн, Өлгий сумд тус бүр 20 га талбайд тэжээлийн ургамал тариалах ажлыг орон нутгийн хөрөнгөөр дэмжих технологийн дагуу хийж гүйцэтгэсэн. 2024 оны байдлаар аймгийн хэмжээнд тэжээлийн ургамал 3704 га талбайд тариалж 10819 тн ургац хураан авлаа.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 70383303, Факс:
Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: https://khovsgol.gov.mn/

2025.05.28 № 3/1323
танай 2025.05.05 -ны № ХЭГ/1258 -т

Г ТАЙЛАН ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ 1

Малчин өрхийн нэгдсэн холбооны эрхзүйн байдлын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой Монгол Улсын Ерөнхий сайдаас Улсын Их Хурлын гишүүний асуусан асуулгатай уялдан аймагт хийж хэрэгжүүлж буй ажлын мэдээллийг мэргэжлийн байгууллагаар гаргуулан хүргүүлж байна.

Холбогдох мэдээллийг хавсаргав.

Хавсралт __ хуудастай.



Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газар

Даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Ганхуяг Гандэлгэр
2025-05-28 18:03:29

**Малчны өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын
тухай хуулийн хэрэгжилтийн тайлан**


Мөрөн

2025 оны 05 дугаар сарын 20

№	Хэрэгжих арга хэмжээ	Биелэлт
1	Малчин өрхийн анхдагч, сумын, аймгийн, нэгдсэн холбооны тогтолцоо бүрдсэн эсэх, уг холбоонд элссэн малчин өрхийн тоо, гишүүнчлэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;	Манай Хөвсгөл аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо 2018 онд шинэчлэн зохион байгуулагдсан бөгөөд 8 сумын 82 БАХ буюу /Бэлчээр ашиглагчдын хэсэг/ бүлэгтэй 2300 гаруй өрх айлууд хамрагдсан байдаг. Тус холбоо нь “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам” -ыг 23 суманд хэлэлцүүлгийг цахим болон танхимаар зохион байгуулж Аймгийн ИТХ -ын 2021.11.19 өдрийн №03 тогтоолоор баталж, МУ-ын Хууль зүй, Дотоод хэргийн яамны 2022.02.23 өдрийн захиргааны хэмжээний 5743 актаар баталгаажсан юм.
2	Дээрх тогтолцооны дагуу тухайн шатны төрийн бодлого үйл ажиллагаанд малчин өрх, малчдын холбооны эрх ашгийг хангаж, төрийн үйлчилгээ, зээл, санхүүгийн хүртээмж нэмэгдэж байгаа эсэх талаар;	Үйл ажиллагаа явагдаагүй байна.
3	Энэхүү хууль хэрэгжиж эхэлснээр малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдах, боловсрол эзэмших, ур чадвараа дээшлүүлэх, малчдын залгамж халаа бэлтгэх, бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, өвлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, түүний явц, үр дүнгийн талаар;	Малчны өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолоор батлагдсан "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай", Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нелөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газрын 2024 оны Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай 166 дугаар тогтоол, "Цагаан алт" үндэсний хөтөлбөр, "Бүтээлч Хөвсгөлчүүд" аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус танилцуулан ажиллаж байна. "Амьдрах орчноо сайжруулж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих жил"-ийн хүрээнд "Бүтээлч Хөвсгөлчүүд" малчдын зөвлөгөөнийг 23 сум 1 тосгонд зохион байгуулж Төрийн бодлого шийдвэрийг таниулах, сурталчлах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ

		цэнийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг зөв төлөвлөж, малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, малын үргил селекцийн ажлыг оновчтой зохион байгуулах, малыг ялган тэмдэглэж бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэхийн ач холбогдол, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломжийн талаар нийт 4760 малчинд сургалт сурталчилгаа хийн ажиллаа.
4	Хууль хэрэгжиж эхэлснээр малын эрүүл мэнд, үргил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, түүний чанарыг сайжруулах, нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр гарч буй үр дүн;	2025 онд "Хөвсгөл аймагт хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах (stream+) төсөл"-тэй хамтран Галт, Жаргалант, Төмөрбулаг сумдын Эрчим хар, Монгол үүлдрийн ямааны үндсэн ашиг шимийн түвшинг тогтоох, ашиг шим өндөр ямаан сүрэг өсгөн үржүүлж буй малчдын тодорхойлж, тус малчдаас стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгч бойжуулах зорилгоор 104 өрхийн 13061 толгой хээлтэгч, 445 толгой хээлтүүлэгч нийт 13506 толгой малд үзлэг ангилалтын ажлыг зохион байгуулж Эрчим хар үүлдрийн 300 толгой ухна ишиг ангилан ялгалт хийж Галт, Жаргалант сумдад гэрээгээр ашиглуулахаар ажиллаж байна.
5	Бэлчээрийг гэрээгээр ашиглах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, малын тоо толгойг бэлчээрийн даацаад тохируулах, сэлгэх нүүдэллэх, бэлчээрийг нөхөн сэргээх чиглэлээр гарч буй ахиц, үр дүнгийн талаар;	Манай аймгийн Бүрэнтогох, Цагаан-Уул, Галт, Жаргалант, Их-Уул, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Түнэл, Алаг-Эрдэнэ-Хатгал, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Ренчинлхүмбэ, Шинэ-Идэр нийт 13 сум 1 тосгон орон нутгийнхаа онцлогт тохируулан "Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам" боловсруулан сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

6	Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах харилцааг төлөвлөх, шийдвэр гаргах, гэрээ байгуулах, гэрээг бүртгэх, дүгнэх, бэлчээрийг зохистой ашиглах чиглэлээр тус хуулиар хүлээсэн үүргээ төрийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж байгаа байдал, тулгамдаж байгаа асуудал, бэлчээрийн ашиглалт, түүний үр дүнгийн талаар;	Бэлчээр ашиглалт, хамгаалах, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах, малын чанарыг сайжруулах, сүргийн эргэлтийг төлөвлөх, малын тэжээлийн ургамал тариалах, өвөлжөө, хаваржааны хөл бууцанд ногоон тэжээл тариалах арга технологи, бэлчээрийн менежмент сайжруулах чиглэлээр давхардсан тоогоор 5142 малчид, иргэдэд сургалт мэдээлэл зөвлөмж өгч ажилласан. 2024 онд аймгийн хэмжээнд 16 сумын 545 иргэн 8 ААН, хоршоо 2788 га талбайд ногоон тэжээл тариалж 3210 тн тэжээл хураан авсан.
7	Хууль хэрэгжих эхэлснээр нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын зүгээс малчдын холбооны эрх ашгийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнгийн талаар;	Малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан 2024 онд 1,378,490 толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, 278,240 толгой малыг хүнсэнд хэрэгцээлсэн байна.

ТАЙЛАН БИЧСЭН:
ХХААГЫН МААХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН 
ХЯНАСАН: **Н.БЭЛЭГДЭМБЭРЭЛ**
ХХААГЫН МААХ-ИЙН ДАРГА 
Б.БЯМБАСҮРЭН



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас 7058-4202, факс 7058-4584
Цахим шуудан azdtg@domod.gov.mn
Цахим хуудас Domod.gov.mn

2015.05.27 № 7/1325
танай 2015.05.05 -ны № 7/13258 -т


Г МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Таны амгаланг айлтгая.

Таны ирүүлсэн албан бичигтэй танилцлаа.

Тус аймгийн хэмжээнд Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг хавсралтаар гарган хүргүүлэв.

Хавсралт: 3 хуудастай



Айтийн Засаг дарлын зоны
05 дугаар сарын 27-ны өдөрийн
1/315 дугаартай албан бичгийн хавсралт

МАЛЧИН ӨРХИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ӨРХ ЗҮЙН
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ

1. Малчин өрхийн анхдагч, сумын, аймгийн, нэгдсэн холбооны тогтолцоо бүрдсэн эсэх, уг холбоонд элссэн малчин өрхийн тоо, гишүүнчлэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

-Малчин өрхийн анхдагч, сумын, аймгийн, нэгдсэн холбооны тогтолцоо бүрдэж үйл ажиллагаа эрхлээгүй байна.

-Аймагт нэгдсэн холбоо байгуулагдаагүй байна.

2. Дээрх тогтолцооны дагуу тухайн шатны төрийн бодлого үйл ажиллагаанд малчин өрх, малчдын холбооны эрх ашгийг хангаж, төрийн үйлчилгээ, зээл, санхүүгийн хүртээмж нэмэгдэж байгаа эсэх талаар

-Ямар нэг, зээл, санхүүгийн дэмжлэг хүссэн хүсэлт ирээгүй байна.

-Нийгмийн цогц явуулын үйлчилгээний хүрээнд 9 байгууллагын 22 албан хаагч газар олголт, хөдөө аж ахуй, малын эрүүл мэнд, хөдөлмөр халамж, соён гэгээрүүлэх, нийгмийн даатгал, иргэний бүртгэл, эрүүл мэндийн тусламжийн чиглэлээр 10,900 малчин, иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн зэрэгцээ, ахуй үйлчилгээний үйлчилгээ үзүүлсэн байна.

-Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөдөлгөөний хүрээнд 120 хоршооны 423 гишүүн малчдыг 16,8 сая төгрөгийн зээл хамруулсан байна.

3. Энэхүү хууль хэрэгжиж эхэлснээр малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдах, боловсрол эзэмших, ур чадвараа дээшлүүлэх, малчдын залгамж халаа бэлтгэх, бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, өвлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, түүний явц, үр дүнгийн талаар

-Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх мэдлэг олгох, чадавхжуулах зорилгоор "Малчны чадамжийн гэрчилгээ" олгох болино хугацааны сургалтад 14 сумын 15-45 насны 22 малчин өрхийг хамруулсан.

-Малчдын залгамж халаа бэлтгэх зорилгоор 14 сумын 35-аас доош насны залуу малчдын төлөөлөл, хоршооны төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллагууд нийт 192 төлөөлөгчдийг оролцуулсан "Эрсдэлгүй мал аж ахуй - Шинэ хөдөө" уриатай аймгийн "Залуу Малчдын зөвлөгөөн-2024" зохион байгуулсан.

4.Хууль хэрэгжиж эхэлснээр малын эрүүл мэнд үржил, ашиг шимийг дээшлүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, түүний чанарыг сайжруулах, нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр гарч буй үр дүн

-Малын ашиг шим чанарыг сайжруулах ажлын хүрээнд Барга үүлдрийн 40 толгой хуц, Буриад омгийн 40 толгой хуц, нийт 80 толгой хуцыг 3 сумын 227 малчдад түрээсээр нийлүүлсний үр дүнд дээрх малчдын мал сүрэг баталгаажсан үүлдэр, омгийн хээлтүүлэгчээр хангагдаж тус малчдын малын шим 15-20 хувь нэмэгдэх нөхцөл бүрдсэн байна.

-Малчин, мал ахуй, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчид 17 аж ахуй нэгжийн 29 төрлийн бүтээгдэхүүнийг борлуулах зориулалт бүхий борлуулалтын 5 цэгийг Халхгол, Хөлөнбуйр, Дашбалбар, Хэрлэн сумдад байгуулан өдөрт дунджаар 6.2 тонн төмс хүнсний ногоо, 0.5 тонн сүү цагаан идээ, 50 кг зөгийн бал зэргийг борлуулан малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх эхлэлийг тавьж ажиллаж байна.

5.Бэлчээрийг гэрээгээр ашиглах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах, сэлгэх нүүдэллэх, бэлчээрийг нөхөн сэргээх чиглэлээр гарч буй ахиц, үр дүнгийн талаар

-Дорнод аймгийн бэлчээр ашиглах, хамгаалах журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 5 хуралдааны 05/01 дүгээр тогтоолоор батлуулан, холбогдох судалгаа тооцооны хамтаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд захиргааны хэм хэмжээний актаар батлуулахаар уламжлаад байна.

6.Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах харилцааг төлөвлөх, шийдвэр гаргах, гэрээ байгуулах, гэрээг бүртгэх, дүгнэх, бэлчээрийг зохистой ашиглах чиглэлээр тус хуулиар хүлээсэн үүргээ төрийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж байгаа байдал, тулгамдаж байгаа асуудал, бэлчээрийн ашиглалт, түүний үр дүнгийн талаар

-Бэлчээрийг зүй зохистой ашиглах чиглэлээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Хадлангийн газрыг бусдад ашиглуулах асуудлыг төлөвлөх, баталгаажуулах, гэрээ байгуулах, хяналт тавих журам”, 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 6/01 тогтоолоор тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

-Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах гэрээний загвар батлагдаж гараагүй боловсруулах шатандаа хийгдэж байна.

7.Хууль хэрэгжиж эхэлснээр нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын зүгээс малчдын холбооны эрх ашгийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах, малын тоо, толгойг бэлчээрийн даацад тохируулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнгийн талаар;

-Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-т бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөнд үе шаттай төлөвлөж, хэрэгжүүлэхээр заасан бөгөөд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас сумдын Засаг дарга нарт жил бүр фото мониторингийн үр дүнгээр бэлчээр ашиглалтын нөлөөнд хүчтэй болон маш хүчтэй орсон буюу талхлагдсан бэлчээрийг хамгаалах, сайжруулах арга хэмжээг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган ажиллах талаар зөвлөмж, чиглэл хүргүүлэн ажилласан.

---oOo---